БАТЛАВ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Э.АМАРТҮВШИН
2024 оны 03 сарын 18 өдөр

3865371.☎4119284050

ТОГООЧИЙН МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ БАРАА МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Бараа бүтээгдэхүүн бүрт тавигдах нийтлэг шаардлага: Монгол улсын хүнсний стандартад нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан, Баталгаат лабораторит шинжлүүлсэн эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, сав баглаа боодлын стандарт алдагдаагүй, хадгалалт тээвэрлэлтийн горимыг зөрчөөгүй, зориулалтын машинаар тээвэрлэсэн, хугацаа хэтрээгүй, стандартад нийцсэн шошго, тэмдэглэгээтэй, шаардлагатай хүнсийг гарал үүслийн бичигтэй ирүүлэх. НИЙЛҮҮЛЭЛТ БҮРД ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ ШААРДАНА.

№	Материалын нэр	Хэмжих нэгж	тоо хэмжээ	Стандарт	Техникийн ерөнхий шаардлага
1	Гурил	кг	11590	MNS 0244 : 2009	Буудайн гурилны хэвийн үнэртэй, исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй, исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй, зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл зажлагдахгүй, бөөгнөрч хатуурсан хэсэг үүсэзгүй, сав баглаа боодол, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
2	Цагаан будаа	кг	5124	MNS ISO 7301 : 2000	Харлаж цоохортоогүй, хөгцний амт үнэргүй, хортон мэрэгч шавьж, тэдгээрийн өт, авгалдай, ялгадасаар бохирлогдоогүй, том ширхэгтэй, цагаан будааны тоос, буталсан үрийн хэсэггүй, өнгө нь хэт цагаан биш, гэхдээ шарласан туяагүй байна. Дунд үрийн 5-6 мм хэмжээтэй байх
3	гурвалжин будаа	кг	183	MNS 6511 : 2015	шаравтар болон бор туяатай цайвар өнгөтэй, гурвалжин будааны өөрийн өвөрмөц үнэртэй, хөгцөрч муудсан болон гадны өөр төрлийн үнэргүй, өөрийн өвөрмөц амттай, исгэлэн гашуун амтгүй, цэцэгийн хайрснаас салгаж цэвэрлэсэн, гурван талт самранцар үр
4	гоймон		3965	MNS 0142 : 1985	Нэр төрөл ангилалдаа тохирсон амт, үнэртэй, хөгцөрсөн гашуун исгэлэн буюу гадны үнэр амтгүй, гүйцэт болтол чанах явцад хэлбэр дүрсээ алдахгүй, хөндий гоймон бол заадсаараа задарч салахгүй, хоорондоо бөөгнөрөхгүй байх, нэр төрөлдөө тохирсон зөв хэлбэр дүрстэй байх
5	лапша гоймон /3кг/		396.5		
6	Шар лууван	кг	4575	MNS 0270 : 2020	Луувангийн өөрийн өвөрмөц ааглаг амттай, гадны амт үнэргүй, хэрэглээнд тохирсон болцтой, хөгшрөөгүй, хэлбэр дүрсийн өөрчлөлтгүй, хальс бүтэн гэмтээгүй, зөөлрөөгүй, цэвэрхэн, тухайн сортын үндсэн шинжид нийцсэн байх
7	Төмс	кг	20374	MNS 0258 : 2021	Булцуу нь бүтэн, цэвэр, эрүүл , шинэ, хальстай, илүүдэл чийгүй, соёогүй, өлсөж зөөлрөөгүй, хортон шавьжид нэрвэгдээгүй, сортын шинжийг хадгалсан, дулаанаас үүдэлтэй хүрэн толбогүй, ногоороогүй, гадны үнэр амтгүй байх,

8	Бөөрөнхий байцаа	кг	4087	MNS 0255 : 2020	Тухайн сортын үндсэн шинжид нийцсэн хэлбэр, өнгөтэй, шинэ, эрүүл, илүүдэл усгүй, боолт чанга, гадна навч гэмтээгүй байх
9	Бөөрөнхий сонгино	кг	762.5	MNS 0260 : 2022	Сонгины өвөрмөц аагтай амттай, гадны амт үнэргүй, болц бүрэн гүйцсэн, бүтэн, цэвэр, нягт, булцууны хүзүү хуурай, сайн хумьсан, ургаж соёолоогүй байх
10	Шар манжин	кг	3660	MNS 0268 : 2020	Манжингийн өөрийн өвөрмөц амттай, гадны үнэр амтгүй, хэрэглээнд тохирсон болцтой, шинэ, эрүүл, хагаралтгүй, хөгшрөөгүй, нягт, шүүслэг, хөндий зайгүй, хальс бүтэн гэмтээгүй, хэлбэр дүрсийн өөрчлөлтгүй байх.
11	Чацаргана	кг	305	MNS 0916 : 2011	Бөөрөнхий зууван хэлбэртэй, шар буюу улаавтар өнгөтэй, шинэ, болц гүйцсэн, хортон шавьжид идэгдэж гэмтээгүй, гадны илүүдэл чийгтгүй, жимсний өвөрмөц үнэртэй, исгэлэн чихэрлэг, тосорхог амттай, гадны амт үнэргүй боловсорч гүйцсэн байх
12	давс	кг	1098	MNS 5046 : 2019	Орос давс эсхүл түүнтэй дүйцэх, нунтаг цагаан өнгөтэй, бөөгнөрч чийг аваагүй, хатуураагүй, иоджуулсан, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй, лабораторийн шинжилгээний бичигтэй, Эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан, хадгалалтын хугацаа хэтрээгүй байх
13	цай	кг	30.5	MNS 5131 : 2002	Ургамлын иш, навч, үр жимснээс бүрдсэн, хуурай хөгцрөөгүй, гадны бохирдолгүй, цайны болон эмийн ургамлын өвөрмөц анхилуун үнэр амттай, гадны үнэр амтгүй, бор ногоон өнгөтэй, хадгалалт, тээвэрлэлийн горим алдагдаагүй, стандартын шаардлага хангасан, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
14	Элсэн чихэр	кг	1830	MNSCAC 212 : 2014	Стандарт шаардлагыг хангасан, гадны ямар нэгэн гадны хольцгүй, хатуурч бөөгнөрөөгүй, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
15	Ургамлын тос	ш	2288	MNS 6646 : 2016	Орос ургамлын тос эсхүл түүнтэй дүйцэх, тундасгүй тунгалаг, үнэргүй, нэр төрөлдөө тохирсон сул амттай, хугацаа хэтрээгүй, хадгалалт, тээвэрлэлийн горим алдагдаагүй, стандартын шаардлага хангасан, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
16	Масло	кг	427	MNS 6652 : 2017	Илчлэг чанар сайтай, өөрийн өвөрмөц үнэр амттай, нэгэн жигд цайвар шаргалаас шар өнгөтэй, тосны бүх хэсэгт тосны судалгүй, нэгэн жигд нягт, уян налархай, зүсэлтийн гадаргуу нь гялалзсан, хуурай бөгөөд усны ил дусалгүй, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
17	Дрож	ш	30.5		Хугацаа дуусаагүй, сав баглаа боодлын, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
18	Дошида	ш	91.5	MNS 5519 : 2005	Түүхий эдээс хамаарсан бүтээгдэхүүний өөрийн өвөрмөц амттай, - Хугацаа хэтрээгүй - Хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй - Хөгцөрч муудаагүй - Химийн болон нян судлалын шинжилгээ хийгдсэн - Стандарт шаардлага хангасан, баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
19	Томато паста	ш	244		
20	Ролтон	ш	427		

21	Хуурай сүү	кг	122	MNS 2842 : 2012	Жигд сүүн цагаанаас шаргал өнгөтэй, гадны ямар нэгэн амт үнэргүй, болсон сүүний мэдрэгдэхүйц амт үнэртэй, нэгэн жигд хуурай нунтаг, гадны ямар нэг хольцгүй, нягт бөөгнөрөлгүй, сав баглаа боодлын горим алдагдаагүй, шинжилгээний бичигтэй байх
22	Майонез	кг	183		Хугацаа дуусаагүй, сав баглаа боодлын, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй баталгаат лабораторийн шинжилгээний бичигтэй байх
23	Шөлний байцай /миёог/		61		

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ НЯГТ Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ТООЦООЛОЛ ХИЙСЭН:

НЯРАВ Г.ПҮРЭВЖАРГАЛ

ХООЛ ЗҮЙЧ Н.ЯНЖИНДУЛАМ